



# СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ **ИНФОГРАФИК** **2022 I-X**

ЧИМЗҮҮЛЭЛТ  
ХҮЧИЛГЭЛ  
ДҮҮРГИЙН  
САЛБАР  
СҮХБААТАР  
ДҮҮРГИЙН  
ЭДИЙН  
ЗАСАГ, НИЙГМИЙН  
БАЙДАЛ  
ИНФОГРАФИК  
2022 I-X



## ХҮН АМ

2022 оны эхний 10 сард Сүхбаатар дүүрэгт 1946 хүүхэд шинээр мэндэлж, 1000 хүнд ногдох төрөлт 13.5 болж, өмнөх оны мөн үеийнхээс 0.7 нэгжээр буурчээ.

### 1000 ХҮНД НОГДОХ



Төрөлт 13.5

Нас баралт 4.7

Ердийн цэвэр өсөлт 8.8

Оны эхний 10 сарын байдлаар нас баралт 681 бүртгэгдэж, 2021 оны мөн үеэс 92-оор (11.9%) буурсан бол өмнөх сараас 72-оор (11.8%) нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, сүүлийн 5 жилийн эхний 10 сард

8.8

Хамгийн бага

Хамгийн их

13.2

Ердийн цэвэр өсөлт: Хүн амын тооны  
өсөлт, бууралтыг харуулна.



## ТӨРСӨН ХҮҮХЭД

2021  
I-X



2065

2022  
I-X

1946 ↓

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 10 сард 1932 эх амаржин, 1946 хүүхэд шинээр мэндэлж, 12 амьгүй төрөлт бүртгэгдсэн байна.

Эх, хүүхдийн эндэгдлийн 30 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6 тохиолдоор (25.0%) нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

### ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

22 ↑  
0-1 хүртэлх насын

8 ↑  
1-5 хүртэлх насын

-  
Эхийн эндэгдэл

9 ↑  
Гэрийн төрөлт

10 ↑  
Хяналтгүй төрөлт

### ЭХИЙН ТӨРӨЛТ

Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 5.8 хувиар буурчээ. Гэрийн төрөлтийн 7, хяналтгүй төрөлтийн мөн 10 тохиолдол бүртгэгдсэн байна.



## ЭРҮҮЛ МЭНД

### НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

<b>Халдварт өвчин</b>	<b>211</b>
<b>2021 I-X</b>	
<b>Цочмог халдварт өвчин</b>	<b>16245</b>
	<b>16456</b>
<b>Халдварт өвчин</b>	<b>229</b>
<b>2022 I-X</b>	
<b>Цочмог халдварт өвчин</b>	<b>12967</b>
	<b>13196</b>

2022 оны эхний 10 сард 10.0 мянган хүн тутмын 897 нь цочмог, 16 нь халдварт өвчнөөр өвчилсөн байна.

### ХАЛДВАРТ ӨВЧИН - 229



### ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН - 12967



Коронавирус халварын тохиолдол 2022 оны 1 сард 8765, 2 сард 2641, 3 сард 651, 6 сард 360, мөн 9 сард 205 тохиолдол бүртгэгдсэн сөрөг үзүүлэлттэй байсан бол 4,5,7,8,10 дугаар саруудад бүртгэгдээгүй эерэг үзүүлэлттэй байна.



## НИЙГМИЙН ХАЛАМЖ



Ehalamj системээр 2022 оны 10 сард олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн мэдээ

	2022 I	2022 X
Халамжийн тэтгэвэр	<b>1 815 хүн</b> <b>522.2 сая төг</b>	<b>1 941 хүн</b> <b>545.4 сая төг</b>
Алдарт эх одонгийн мөнгө	<b>7 939 хүн</b> <b>971 сая төг</b>	<b>5 хүн</b> <b>0.5 сая төг</b>
Алдар цолтон ахмад настан хөнгөлөлт	<b>5 хүн</b> <b>1.2 сая төг</b>	<b>357 хүн</b> <b>54.8 сая төг</b>
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	<b>51 525 хүн</b> <b>5 152.5 сая төг</b>	<b>52 681 хүн</b> <b>5 268.1 сая төг</b>
Бусад тэтгэмж	<b>17 516 хүн</b> <b>1 340.9 сая төг</b>	<b>12 935 хүн</b> <b>921.9 сая төг</b>



## НИЙГМИЙН ДААТГАЛ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

	2021 I-X	2022 I-X
<b>ОРЛОГО,</b> тэрбум төгрөг	<b>285.7*</b>	<b>325.4↑</b>
<b>ЗАРЛАГА,</b> тэрбум төгрөг	<b>121.3</b>	<b>150.6↑</b>

### ОЛГОСОН ТЭТГЭВЭР

<b>20.3</b>	<b>21.3↑</b>
<b>Тэтгэвэр авагчийн тоо, мянган хүн</b>	
<b>96.5</b>	<b>125.2↑</b>
<b>Олгосон тэтгэвэр, тэрбум төгрөг</b>	

### ОЛГОСОН ТЭТГЭМЖ

<b>27.1</b>	<b>27.8↑</b>
<b>Хамрагдсан хүн, мянган хүн</b>	
<b>24.8</b>	<b>25.4↑</b>
<b>Олгосон тэтгэмж, тэрбум төгрөг</b>	




## БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


2021 I-X 488



2022 I-X 420 ↓



### БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны аngillaар, дүнд эзлэх хувиар, 2022 I-X



Дүүргийн ХХҮХ-т бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 10 сарын эцэст 420 болж, өмнөх оны мөн үеэс 68-аар (13.9%) буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдээс оны эхний 10 сард 528 иргэн ажилд зуучлагдан орсон нь өмнөх сараас 147-гоор (38.6%) нэмэгджээ.



## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

2021 I-X

1862



2022 I-X

3418 ↑

### 1-р хэлтэс

(1-9 дүгээр хороо)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2133 (62.4%)

Илрүүлэлт 37.7%

### 2-р хэлтэс

(10-20 дугаар хороо)

Бүртгэгдсэн гэмт хэрэг 1285 (37.6%)

Илрүүлэлт 48.4%

Дүүргийн хэмжээнд 2022 оны эхний 10 сард 1-р хэлтэст 2133, 2-р хэлтэст 1285, нийт 3418 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс 1556 хэргээр 1.8 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн илрүүлэлт дүүргийн хэмжээнд 41.9 хувтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар нэмэгджээ.

Мөн зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл өссөн дунгээр 14736 бүртгэгдсэн байна.



## БҮРТГЭГДСЭН ТҮЙМЭР, ҮЕР, УС

### БҮРТГЭГДСЭН ГАЛ ТҮЙМЭР, төрлөөр

2021 I-X

132



2022 I-X

126 ↓

Объектын



9

Хогны



12

Өнжмөл шар өвсний



16

Үер ус, халиа дошин

2022 оны эхний 10 сард дүүргийн хэмжээнд объектын гал түймрийн 126, хогны 24, өнжмөл шар өвс шатсан 68, халиа дошны 1, нийт 219 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 50-иар буюу 29.6% өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн гал түймрийн өсөлтөд өнжмөл шар өвс шатсан дуудлага 56-гаар буюу 5.7 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.



## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

### ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, сая төгрөг



Төлөвлөгөө 242 516.3  
Гүйцэтгэл 230 238.7  
Биелэлт 94.9%

2022 оны эхний 10 сард дүүргийн төсөвт 230.2 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 94.9 хувиар биелжээ. Төвлөрсөн орлогын 96.2 хувийг урсгал орлого, 3.8 хувийг төсвийн урсгал санхүүжилтийн орлого эзэлж байна.

Харин урсгал орлогын 99.3 хувийг татварын орлого, 0.7 хувийг татварын бус орлого бүрдүүлжээ.

### ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА, сая төгрөг



Төлөвлөгөө 238 968.1  
Гүйцэтгэл 226 622.6  
Биелэлт 94.8%


Оны эхний 10 сарын байдлаар төвлөрсөн орлогоос 98.4%-ийг урсгал зардалд зарцуулаад байна. Урсгал зардлын дийлэнх буюу 99.7%-ийг бараа үйлчилгээний, 0.3%-ийг бусад зардал эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын дийлэнх буюу 73.6%-ийг нийслэлд төвлөрүүлсэн орлогод, 2.3%-ийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалд, 0.3%-ийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд, 23.8%-ийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулжээ.



## АЖ ҮЙЛДВЭР (\*урьдчилсан гүйцэтгэл)

2021 I-X Нийт үйлдвэрлэл 3 033.3 тэрбум төгрөг  
Нийт борлуулалт 6 516.0




2022 I-X Нийт үйлдвэрлэл 2 953.0\* тэрбум төгрөг  
Нийт борлуулалт 9 233.5\* тэрбум төгрөг

### АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

2021 I-X

УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (16.0%↑)

2 387.0 тэрбум төгрөг



2022 I-X

2 768.6\* тэрбум төгрөг

БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ (71.5%↓)


642.8 тэрбум төгрөг



183.1\* тэрбум төгрөг

ЦАХИЛГААН, ДУЛААН, ЭРЧИМ ХҮЧ, УСАН ХАНГАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛ (62.9%↓)

3.5 тэрбум төгрөг



1.3\* тэрбум төгрөг



## ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ



Цэвэрлэсэн зам талбай 436.8 мян.м2

Зарцуулсан хөрөнгө 2 487.5 сая төгрөг

### ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ, байршилаар, 2022 I-X

30 932.0 ↑ ТН Орон сууцнаас

Гэр хорооллоос 17 583.4 ↑ ТН

10 948.3 ↑ ТН Зуслангаас



2022 оны эхний 10 сард дүүргийн хэмжээнд 59.5 мянган тонн хог тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9.8 мянган тонноор буюу 19.6 хувиар өсжээ.

Тээвэрлэсэн хогны 52.0 хувийг орон сууцнаас, 29.6 хувийг гэр хорооллоос, 18.4 хувийг зуслангаас тус тус тээвэрлэжээ.

Хог тээвэрлэлтэд нийт 2487.5 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 843.4 сая төгрөгөөр (51.3%) өссөн үзүүлэлттэй байна.

